



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Завхан аймгийн Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ЗАА-2024/164/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

[www.audit.mn](http://www.audit.mn)

Улиастай сум

2025 он

Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын

дарга, тэргүүлэх аудитор: Д.Бат-Ундраа

Утас: 99993365

Цахим хаяг: [Bat-Undraa@audit.gov.mn](mailto:Bat-Undraa@audit.gov.mn)

Аудитын менежер: Х.Болдбаатар

Утас: 99105506

Цахим хаяг: [Boldbaatarkh@audit.gov.mn](mailto:Boldbaatarkh@audit.gov.mn)

Хаан соёмбо аудит ХХК -Ахлах аудитор: Б.Дагвасүрэн

Утас: 99014227

Цахим хаяг: [b.dagvaa1000@gmail.com](mailto:b.dagvaa1000@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

---

1. Хараат бус аудиторын дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	5
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	6
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	7
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	8
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	8
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	10
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	10
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт	11
4. Аудитын тайлан.....	13
4.1 Ерөнхий зүйл .....	13
4.2 Материаллаг байдал .....	14
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. Аудитын илрүүлэлт .....	16
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл	

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ЗАВХАН АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

81090 Улиастай, Завхан аймаг  
Утас/Факс: 7046-36-12  
И-мэйл: zavkhan@audit.gov.mn

2025.08.19 № 116

Тайлбар: \_\_\_\_\_

ТҮДЭВТЭЙ СУМЫН  
ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Ц.НАЛЖИРМАА-Д

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Түдэвтэй сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Түдэвтэй сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Түдэвтэй сумын Хүүхдийн цэцэрлэг нь 1,100.0 мянган төгрөгийн цахилгаан мотор худалдан авч, Боловсролын ерөнхий газрын хөрөнгө оруулалтаар 8,511.4 мянган төгрөгийн 3 ширхэг зөөврийн компьютер, бусад хандивлагчдаас ирсэн 11,438.3 мянган төгрөгийн хөрөнгө, нийт 21,019.7 мянган төгрөгийн хөрөнгийг үндсэн хөрөнгийн дансанд бүртгэсэн байна. Мөн 2,336.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг холбогдох газруудын шийдвэрээр акталж, бүртгэлээс хассан, байгууллагын 2558 м.кв газрыг эзэмшдэг бөгөөд байгууллагын бусад биет бус хөрөнгийн дансанд 5,116.0 мянган төгрөгөөр үнэлж бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Түдэвтэй сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх аудитаар цэцэрлэгийн эрхлэгчийн тушаал, ажил дүгнэсэн материалгүйгээр 294.2 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл, 1,170.0 мянган төгрөгийн дотоод албан томилолтыг анхан шатны баримтын бүрдэл дутуу, байгууллагын даргын зөвшөөрөлгүйгээр олгож, хүүхдийн хоолны нормативыг сар бүр хянаж ажиллаагүйгээс 750.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Бусад асуудлын хэсэг

Түдэвтэй сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 зорилтын хүрээнд 27 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэл 89 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Д.БАТ-УНДРАА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
I	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	69,364,671.76	102,054,875.23
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	27,962,807.76	61,430,040.83
311	Кассанд байгаа бэлэн мөнгө		
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	27,962,807.76	61,430,040.83
3121	Төгрөг	27,962,807.76	61,430,040.83
31211	Төрийн сангийн харилцах	27,962,807.76	61,430,040.83
35	БАРАА МАТЕРИАЛ	41,401,864.00	40,624,834.40
351	Түүхий эд материал	3,734,890.00	2,522,790.40
3511	Тусгай зориулалттай материал	3,019,150.00	1,977,790.40
3513	Эм боох материал	715,740.00	545,000.00
354	Хангамжийн материал	37,666,974.00	38,102,044.00
3541	Бичиг хэргийн материал	1,114,600.00	882,000.00
3542	Аж ахуйн материал	2,562,220.00	2,997,820.00
3545	Барилгын засварын материал	767,600.00	128,000.00
3546	Хүнсний материал	4,055,436.00	7,223,764.00
3547	Бусад хангамжийн материал	29,167,118.00	26,870,460.00
II	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	228,836,781.84	210,207,428.17
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	228,836,781.84	210,207,428.17
392	Биет хөрөнгө	222,070,781.84	203,441,428.17
39201	Барилга, байгууламж, орон сууц	57,303,913.92	59,303,913.92
39202	Хуримтлагдсан элэгдэл	-46,306,039.82	-55,556,691.90
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	36,321,489.00	54,373,200.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-18,660,928.35	-23,405,886.35
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,299,485.44	16,495,413.44
39208	Хуримтлагдсан элэгдэл	-12,476,202.26	-12,770,130.22
39214	Бусад үндсэн хөрөнгө	227,307,203.24	227,282,303.24
39215	Хуримтлагдсан элэгдэл	-39,492,139.33	-62,515,393.96
39217	Ном	774,000.00	234,700.00
393	Биет бус хөрөнгө	6,766,000.00	6,766,000.00
39301	Програм хангамж	1,650,000.00	1,650,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	5,116,000.00	5,116,000.00
III	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	298,201,453.60	312,262,303.40
IV	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,055,430.00	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,055,430.00	
413	Өглөг	1,055,430.00	

4136	Бусад өглөг	1,055,430.00	
41361	Байгууллагад төлөх өглөг	1,055,430.00	
V	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	297,146,023.60	312,262,303.40
51	Засгийн газрын хувь оролцоо	297,146,023.60	312,262,303.40
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	44,209,429.60	44,209,429.60
51101	Өмч: - төрийн	44,209,429.60	44,209,429.60
512	Хуримтлагдсан үр дүн	196,474,655.45	211,590,935.25
5121	Өмнөх үеийн үр дүн	196,474,655.45	196,474,655.45
5122	Тайлант үеийн үр дүн		15,116,279.80
513	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	56,461,938.55	56,461,938.55
VI	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	298,201,453.60	312,262,303.40

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Данс	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлан он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	490,674,233.00	422,787,511.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	203,885,333.00	19,919,711.00
120	Нийтлэг татварын бус орлого	203,885,333.00	19,919,711.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	203,885,333.00	19,919,711.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	203,885,333.00	19,919,711.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	286,788,900.00	402,867,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	265,506,100.00	374,124,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	265,506,100.00	374,124,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,282,800.00	28,743,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,282,800.00	28,743,300.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	302,737,754.74	407,671,231.20
21	УРСГАЛ ЗАРДАЛ	302,737,754.74	407,671,231.20
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	302,658,025.95	405,621,028.85
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	187,682,412.52	266,739,349.63
210101	Үндсэн цалин	133,616,493.67	178,706,749.53
210102	Нэмэгдэл	43,999,696.30	83,203,940.10
210104	Урамшуулал	10,066,222.55	4,828,660.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	25,397,745.35	32,844,275.30
210201	Тэтгэврийн даатгал	17,955,405.10	22,441,948.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,876,824.12	2,567,181.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,448,000.96	1,273,323.63
210204	Ажилгүйдлийн даатгал	363,866.90	1,281,362.86

210205	Эрүүл мэндийн даатгал	3,753,648.27	5,280,458.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,649,297.21	23,643,367.65
210301	Гэрэл, цахилгаан	3,966,097.21	4,349,667.65
210302	Түлш, халаалт	15,683,200.00	18,793,700.00
210303	Цэвэр, бохир ус		500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,554,900.00	
210401	Бичиг хэрэг	1,554,900.00	
2105	Нормативт зардал	24,919,707.00	27,215,662.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	52,000.00	
210502	Хоол, хүнс	24,867,707.00	27,215,662.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,045,100.00	
210604	Урсгал засвар	1,045,100.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	525,000.00	547,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	525,000.00	547,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,883,863.87	54,630,874.27
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,912,380.00	13,529,809.60
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	540,000.00	1,452,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	34,431,483.87	39,649,064.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,728.79	2,050,202.35
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	79,728.79	2,050,202.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,728.79	2,050,202.35
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	187,936,478.26	15,116,279.80
V	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	187,936,478.26	15,116,279.80

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлан он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	286,788,900.00	402,867,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	286,788,900.00	402,867,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	265,506,100.00	374,124,500.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	265,506,100.00	374,124,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	21,282,800.00	28,743,300.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	21,282,800.00	28,743,300.00

1340	Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих		
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	264,095,852.87	368,300,566.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	264,095,852.87	368,300,566.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	264,016,124.08	366,250,364.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	186,368,957.87	266,739,349.63
210101	Үндсэн цалин	124,333,634.08	178,706,749.53
210102	Нэмэгдэл	51,969,101.24	83,203,940.10
210104	Урамшуулал	10,066,222.55	4,828,660.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24,708,800.00	32,844,275.30
210201	Тэтгэврийн даатгал	16,801,800.00	22,441,948.60
210202	Тэтгэмжийн даатгал	1,976,800.00	2,567,181.66
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,581,400.00	1,273,323.63
210204	Ажилгүйдлийн даатгал	395,200.00	1,281,362.86
210205	Эрүүл мэндийн даатгал	3,953,600.00	5,280,458.55
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	19,053,371.21	24,698,797.65
210301	Гэрэл, цахилгаан	2,910,667.21	5,405,097.65
210302	Түлш, халаалт	16,133,200.00	18,793,700.00
210303	Цэвэр, бохир ус	9,504.00	500,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		
2105	Нормативт зардал	23,328,655.00	30,383,990.00
210502	Хоол, хүнс	23,328,655.00	30,383,990.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,999,700.00	894,300.00
210604	Урсгал засвар	1,999,700.00	894,300.00
2107	Томилолт, зочны зардал		
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	525,000.00	547,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	525,000.00	547,500.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,031,640.00	10,142,152.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,442,860.00	6,897,552.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,588,780.00	3,244,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	79,728.79	2,050,202.35

2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	79,728.79	2,050,202.35
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	79,728.79	2,050,202.35
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	22,693,047.13	34,567,233.07
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,625,000.00	1,100,000.00
	Дотоод эх үүсвэрээр	1,625,000.00	1,100,000.00
223001	Бусад хөрөнгө	1,625,000.00	1,100,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-1,625,000.00	-1,100,000.00
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	21,068,047.13	33,467,233.07
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		27,962,807.76
31	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		61,430,040.83

### ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Засгийн газрын сан	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	ЗГ-н хувь оролцосны дүн
1	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,209,429.60	56,461,938.55	196,474,655.45	297,146,023.60
7	Тайлант үеийн үр дүн			15,671,488.74	15,671,488.74
10	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,209,429.60	56,461,938.55	196,474,655.45	297,146,023.60
17	Тайлант үеийн үр дүн			15,116,279.80	15,116,279.80
19	20... оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	44,209,429.60	56,461,938.55	211,590,935.25	312,262,303.40

#### 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	Дүн	Хувь
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	402,087,100.00	340,657,266.93	61,429,833.07	84.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	402,087,100.00	340,657,266.93	61,429,833.07	84.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	402,087,100.00	340,657,266.93	61,429,833.07	84.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	318,709,300.00	266,739,349.63	51,969,950.37	83.69
210101	Үндсэн цалин	222,020,300.00	178,706,749.53	43,313,550.47	80.49
210102	Нэмэгдэл	92,278,400.00	83,203,940.10	9,074,459.90	90.17

210104	Урамшуулал	4,410,600.00	4,828,660.00	-418,060.00	109.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	37,710,600.00	32,844,275.30	4,866,324.70	87.1
210201	Тэтгэврийн даатгал	25,643,700.00	22,441,948.60	3,201,751.40	87.51
210202	Тэтгэмжийн даатгал	3,016,400.00	2,567,181.66	449,218.34	85.11
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,508,400.00	1,273,323.63	235,076.37	84.42
210204	Ажилгүйдлийн даатгал	1,508,400.00	1,281,362.86	227,037.14	84.95
210205	Эрүүл мэндийн даатгал	6,033,700.00	5,280,458.55	753,241.45	87.52
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал				
2105	Нормативт зардал	31,268,800.00	30,383,990.00	884,810.00	97.17
210502	Хоол, хүнс	31,268,800.00	30,383,990.00	884,810.00	97.17
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,281,900.00	547,500.00	734,400.00	42.71
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,281,900.00		1,281,900.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ		547,500.00	-547,500.00	
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	13,116,500.00	10,142,152.00	2,974,348.00	77.32
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,345,400.00	6,897,552.00	2,447,848.00	73.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	3,771,100.00	3,244,600.00	526,500.00	86.04
1	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	402,087,100.00	374,124,500.00	27,962,600.00	93.05
131	Улсын төсвөөс санхүүжих	402,087,100.00	374,124,500.00	27,962,600.00	93.05
131001	Улсын төсвөөс санхүүжих	402,087,100.00	374,124,500.00	27,962,600.00	93.05
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		27,962,807.76	-27,962,807.76	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		61,430,040.83	-61,430,040.83	
1	Төсвийн бусад мэдээллийн ангилал				
2	Байгууллагын тоо	1	1		
5	Ажиллагсадын тоо	11	11		
6	Удирдах ажилтан	1	1		
7	Гүйцэтгэх ажилтан	3	3		
8	Үйлчлэх ажилтан	7	7		

## 2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31

/төгрөгөөр/

ДАНС	ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ	ДҮН	Хувь
2	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	28,743,300.00	26,693,097.65	2,050,202.35	92.90
21	Урсгал зардал	28,743,300.00	26,693,097.65	2,050,202.35	92.90
210	Бараа, ажил үйлчилгээний зардал	26,743,300.00	24,698,797.65	2,044,502.35	92.35
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	26,743,300.00	24,698,797.65	2,044,502.35	92.36
210301	Гэрэл, цахилгаан	7,149,600.00	5,405,097.65	1,744,502.35	75.6
210302	Түлш, халаалт	18,793,700.00	18,793,700.00		100
210303	Цэвэр, бохир ус	800,000.00	500,000.00	300,000.00	62.5
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,000,000.00	1,994,300.00	5,700.00	99.7
210604	Урсгал засвар	2,000,000.00	1,994,300.00	5,700.00	99.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		2,050,202.35	-2,050,202.35	
	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		2,050,202.35	-2,050,202.35	
1	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр		28,743,300.00	-28,743,300.00	

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

##### **Завхан аймгийн Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн чиглэл:**

Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсролын зорилго, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх, хүүхдийг асрах, хамгаалах, тэдний хөгжил, төлөвшлийг дэмжсэн цогц үйл ажиллагаа эрхэлнэ.

##### **Завхан аймгийн Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн зорилго:**

Завхан аймгийн Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэг нь бага насны хүүхдийн бие бялдар, танин мэдэхүй, нийгэмшлийн хөгжлийг дэмжиж, сургуульд бэлтгэх, суралцагчийг бие даан сурч, амьдрахад шаардагдах суурь мэдлэг, чадварыг хөгжүүлж, ёс суртахуунтай, хариуцлагатай, ажил мэргэжлийн чиг баримжаатай иргэнийг төлөвшүүлэх зорилготой үйл ажиллагаагаа явуулж байгаа Боловсрол Шинжлэх Ухааны яамны харьяа байгууллага юм.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 50 арга хэмжээ төлөвлөснөөс 95.6 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжсэн байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

##### **Завхан аймгийн Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль:**

1. Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль
2. Боловсролын ерөнхий хууль
3. Төрийн хэмнэлтийн тухай хууль
4. Төрийн албаны тухай хууль
5. Төсвийн тухай хууль
6. Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
7. Нийгмийн даатгалын ерөнхий хууль
8. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

9. Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
10. Хувь хүний орлогын албан татварын тухай хууль
11. Хөдөлмөрийн тухай хууль
12. Шилэн дансны тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль, бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй бөгөөд "төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай", "орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай", "цэцэрлэгийн хүүхдийн хоолны нэг өдрийн зардлын хэмжээг нэмэгдүүлэх" зэрэг Засгийн газрын тогоолуудад өөрчлөлт орсон байна.

**Байгууллагын дотоод хяналтын талаар:** Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ. Тус цэцэрлэг нь дотоод хяналтын нэгжгүй бөгөөд Санхүүгийн өдөр тутмын ажил гүйлгээнд байгууллагын дарга, санхүүгийн ажилтан төрийн сангийн мэргэжилтэн нар хяналт тавин ажиллаж байна.

Дотоод хяналтын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Завхан аймгийн Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдлийн дагуу бэлтгэж толилуулсан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.5 дахь заалтын дагуу иж бүрэн гаргаж ирүүлсэн.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Завхан аймгийн Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө өмнөх оноос 11,558.7 мянган төгрөгөөр буюу 1 хувиар буурсан нь биет болон биет бус хөрөнгийн өөрчлөлттэй холбоотой байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	27,962.8	61,430.0	33,467.2
Авлага	0	0	0
Бараа материал	41,401.9	40,624.8	-777.1
Үндсэн хөрөнгө	228,836.8	210,441.4	-18,395.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>298,201.4</b>	<b>312,262.3</b>	<b>14,060.9</b>
Өр төлбөрийн дүн	1,055.4	0	-1,055.4

Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	297,146.,0	312,262.3	15,116.3
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>298,201.4</b>	<b>312,262.3</b>	<b>14,060.9</b>

Санхүүгийн тайлангийн тодруулгыг мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, авлага, бараа материал, өр төлбөр гэсэн данс бүрээр холбогдох журам, зааврын дагуу бэлтгэсэн байна.

#### **Тайлант онд:**

Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл өмнөх оноос 33,467.2 мянган төгрөгөөр өсч, бараа материал үлдэгдэл 777.1 мянган төгрөгөөр, үндсэн хөрөнгийн үлдэгдэл 18,395.4 мянган төгрөгөөр тус тус буурсан байна. Энэ нь ашиглах боломжгүй болсон, эвдэрч хэмхэрсэн, муудаж хуучирсан бараа материал, тавилга хэрэгслийг холбогдох байгууллага, албан тушаалтны шийдвэрээр бүртгэлээс хассантай холбоотой байна гэж үзлээ.

Тус цэцэрлэг нь оны эхэнд 41,401.9 мянган төгрөгийн бараа материалын үлдэгдэлтэй байсан бөгөөд тайлант онд төсвийн хөрөнгөөр 37,709.1 мянган төгрөгийн бараа материалыг худалдан авч 32,486.9 мянган төгрөгийн зарцуулалт хийж, 5,999.2 мянган төгрөгийн тусгай зориулалттай материал, аж ахуйн болон бусад хангамжийн материалыг холбогдох газрын шийдвэрээр акталж, устгаснаар оны эцэст 40,624.8 мянган төгрөгийн үлдэгдэлтэй болсон байна. Үндсэн хөрөнгийн хувьд 1,100.0 мянган төгрөгийн цахилгаан мотор худалдан авч, Боловсролын газар, аймгийн болон сумын ОНХ-ийн сангаас нийлүүлэгдсэн 19,919.7 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга хэрэгслийг цэцэрлэгийн эрхлэгчийн 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн А/10 тоот тушаалаар орлогот авч бүртгэлд тусгажээ. 2,336.3 мянган төгрөгийн хөрөнгийг сумын ИТХ-ын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 13 дугаар тогтоолоор бүртгэлээс хасч, 39,649.1 мянган төгрөгийн элэгдлийн зардал тооцсон байна.

Тайлант онд өмнөх оны 1,055.4 мянган төгрөгийн байгууллагат төлөх өглөгийг барагдуулж, оны эцэст өглөг, авлага үүсгээгүйажилласан нь төсвийг зөв зохистой удирдан зарцуулж чадсантай холбоотой байна.

### **3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Засгийн газрын 2024 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаар батлагдсан “төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэх тухай”, “орон нутагт ажилласны нэмэгдлийг тооцож олгох тухай” 82, 128 дугаар тогтоолуудын дагуу ажилчдын цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл нэмэгдэж, төсвийг тодотгосноор тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 371,124.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 28,743.3 мянган төгрөгөөр, зардлыг 402,867.8 мянган төгрөг байхаар тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлэн, батлуулж ажилласан байна.

#### **3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 367,350.3 мянган төгрөг буюу 90.0 хувьтай байна. Энэ нь цалин хөлс болон нэмэлт урамшууллын зардлыг 51,969.9 мянган төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шийтгэлийг 4,866.7 мянган төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой зардлыг 2,044.5 мянган төгрөгөөр, хүүхдийн хоолны зардлыг 884.8 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийг 734.4 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2,447.8 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

### **Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл**

*/мянган төгрөгөөр/*

Хөтөлбөрг а хэмжээ	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
<b>Улсын төсвөөс санхүүжих</b>					
71801	Сургуулийн өмнөх боловсрол	379,394.5	340,657.2	38,737.3	89.79
80233	Хүүхэд хамгааллын зардал	564.4	0	564.4	0
81605	Эрүүл мэндийг дэмжих зардал	870.2	670.0	200.2	76.9
81807	Цэцэрлэгийн хүүхдийн хоолны зардал	31,268.8	30,384.0	884.8	97.17
81816	Зөв монгол хүүхэд үндэсний хөтөлбөр	1,890.5	1,890.5	0	100
81823	Багш ажилчдын мэргэжил дээшлүүлэх зардал	870.2	80.0	790.2	9.1
81834	Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардал	340,019.3	304,156.2	35,863.1	89.5
81835	Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах зардал	3,911.1	3,476.5	434.6	88.9
<b>Дүн</b>		<b>379,394.5</b>	<b>340,657.2</b>	<b>38,737.3</b>	<b>89.79</b>
<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>					
80109	Тогтмол зардал	28,743.3	26,693.1	2,050.2	92.9
<b>Нийт дүн</b>		<b>408,137.8</b>	<b>367,350.3</b>	<b>40,787.5</b>	<b>90.0</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр орон нутгийн төсвөөс 28,743.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, байр ашиглалттай холбоотой зардалд 24,698.8 мянган төгрөг, урсгал засварын зардалд 1,994.3 мянган төгрөгийг тус тус зарцуулж, 2,050.2 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэлийн талаар

№	Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан арга	Бараа ажил үйлчилгээний нэр	Төлөвлөлт	Гүйцэтгэл
1	АУЭХС шүүд гэрээ байгуулсан	Гэрэл цахилгаан	7,149.6	5,405.1
2	Шинэ зуун энерги ХХК шүүд гэрээ байгуулсан	Халаалтын зардал	18,793.7	18,793.7
3	Жамуух хоршоо шүүд гэрээ байгуулсан	Хоол хүнс, бусад	14,202.2	14,202.2
4	Буман цэцэн хайрхан ХХК шүүд гэрээ байгуулсан	Хоол хүнс	9,449.0	9,449.0

5	Бусад аж ахуйн нэгж, иргэдтэй шүүд гэрээ байгуулсан	Хоол хүнс	7,617.6	6,732.8
	<b>Дүн</b>		<b>57,212.1</b>	<b>54,582.8</b>

Тайлант оны худалдан авах ажиллагаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцсэн, Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоолоор баталсан босго үнийг баримталсан байна. Худалдан авах ажиллагаатай холбоотой зөрчилтэй зүйл илрээгүй болно. Гэрээ байгуулсан аж ахуйн нэгж, иргэдтэй оны эцэст тооцоо нийлж, өглөг, авлагагүй гэдгээ баталгаажуулж, баримтжуулсан байна.

#### 4. АУДИТЫН ТАЙЛАН

##### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Завхан аймгийн Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Хаан соёмбо аудит ХХК-ний аудитор Р.Мядагмаа хийж, анхан шатны хяналтыг ахлах аудитор Б.Дагвасүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг Завхан аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Ц.Оюунсүвд, аудитын менежер Х.Болдбаатар, дарга, тэргүүлэх аудитор Д.Бат-Ундраа нар хэрэгжүүлсэн.

Завхан аймгийн Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэг нь 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Завхан аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

##### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг тооцох эх сурвалжийг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 302,737.7 төгрөгөөс 1.5 хувиар тооцож, 4,541.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг 75,0 хувь буюу 3,405.8 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг түвшинг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

##### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн шалгуур үзүүлэлтээс тухайн шалгагдагч байгууллагатай хамааралтай 31 заалтыг сонгож, горим сорил хэрэгжүүлсэн бөгөөд алдаа, зөрчил илрээгүй байна.

##### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Байгууллагын 2024 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

#### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 5 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль, тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

##### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Завхан аймгийн Түдэвтэй сумын хүүхдийн цэцэрлэгийн 2024 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй.

##### **4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар түүвэрт хамрагдсан тул акт, албан шаардлага, зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### **4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал**

1. Гэрэл цахилгааны үнийг төлөхдөө нэхэмжлэлд бичигдсэн зөвхөн 1 гэсэн квт-ыг үндэслэн шилжүүлэг хийж байна. Холбогдох байгууллагаас үндсэн нэхэмжлэлийг авч, тоолуурын заалтыг хянаж, мөнгийг шилжүүлж хэвших

### **5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ**

Аудитаар нийт 2,214.8 мянган төгрөгийн алдаа илэрч 294.2 мянган төгрөгийн төлбөрийн акт, 1,920.6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

#### **5.1 Төлбөрийн акт**

Бүлгийн багшид эрхлэгчийн тушаалгүйгээр ур чадварын нэмэгдэл олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13,7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4 “хуулиар зөвшөөрөөгүй бусад”, төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” заалтуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн байдал: Төлбөрийн акт тогтоох**

#### **5.2 Албан шаардлага: өгөгдөөгүй**

#### **5.3 Зөвлөмж:**

1. Дотоод албан томилолтын мөнгийг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар олгосон нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13,7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэсэн заалтыг зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн байдал:** Гүйлгээг хийхдээ анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах

2. Цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тоог хоолны нормативт зардлаар тооцон үзэхэд хүүхдийн хоолны нормативыг хүүхдэд өгөх нормативаас дутуу олгож, зарцуулсан нь Засгийн газрын 2019 оны 450 дугаар тогтоол, 2024 оны 237 дугаар тогтоолуудыг тус тус зөрчсөн байна.

**Шийдвэрлэсэн байдал:** Хүүхдийн хоолыг захиалгын хуудсанд бичихдээ нормативыг мөрдөх, сар бүр хяналтыг тавьж байх

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчил нь бидний тогтоосон материаллаг түвшинөөс хэтрээгүй байгаа тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өглөө.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**

**Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруу-лаагүй	Тоо	Дүн

/Мянган төгрөгөөр/

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/Мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Еүлгийн багшид эрхлэгчийн тушаалгүйгээр ур чадварын нэмэгдэл олгосон	1	294.2	1	294.2								
Дотоод албан томилолтын мөнгийг анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар олгосон	1	1,170.0					1	1,170.0				
Цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхдийн тоог хоолны нормативт зардлаар тооцон үзэхэд хүүхдийн хоолны нормативыг хүүхдэд өгөх нормативаас дутуу олгож, зарцуулсан	1	750.6					1	750.6				
	3	2,214.8	1	294.2			2	1,920.6				

Үүнээс

/Мянган төгрөгөөр/

АУДИТЫН ТАЙЛАНГ:

ХЯНАСАН:

АХЛАХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Огноо: 2025-02-20

БОЛОВСРУУЛСАН:

АТД:366 9039376  
0921100009

Ц.ОЮУНСУВД  
Х.БОЛДБААТАР  
Д.БАТ-УНДРАА

"ХААН СОЁМБО АУДИТ" ХХК-НИЙ АУДИТОР

Огноо: 2025-02-20

Р.МЯДАГМАА